

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОЙН АНГИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА-2023/34-ШТА-ГА

**БУЛГАН АЙМАГ
2023 ОН**

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 7034-2495 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn
Аудитор: З.Ганбаатар
Утас: 7034-2495 Цахим хаяг: Ganbaatarz@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
bulgan@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТАБ	Төрийн аудитын байгууллага
УИХ	Улсын Их Хурал
СДОА	Сум дундын ойн анги
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НББ	Нягтлан бодох бүртгэл

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

1. Аудитын зорилт:

“Ойн ангиудын үйл ажиллагааны үр дүн” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, аймаг, сумын ЗДТГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

**Аудитын
хамарсан хүрээ**

Аудитад сум дундын ойн ангиуд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, ойн мэргэжлийн байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаа, тухайн байгууллагад холбогдох хуулийн дагуу хяналтын чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудын хяналт шалгалтын үйл ажиллагааг тус тус хамруулсан.

Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулахгүй болно.

**Аудитын арга
зүй, шалгуур
үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор Б.Энхтөр, З.Ганбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн 2023 оны 04 дүгээр сарын 27-ноос 2023 оны 06 дугаар сарын 02-ны хооронд гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Ойн ангийн үндсэн зорилт нь ойн баялгийн нөөцийг судлан тогтоож хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх Ойн аж ахуйн арга хэмжээ явуулах тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, ойн санг гэрээгээр иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, ойн санд учирсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ хийх, ойн хөнөөлт шавж, өвчний голомтын тойм судалгаа хийж дүгнэлт гаргах, ойн төлөв байдалд үнэлгээ өгөх, ойн тооллого, бүртгэл, зохион байгуулалт, хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлын явцад хяналт шинжилгээ хийх, ойжуулалт, ойн аж ахуйн болон ойн ашиглалтын арга хэмжээний шинэ техник, технологийг турших, нутагшуулах, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах, бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах, бусад шаардлагатай мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд оршдог.

Ойн тухай хуулийн 14.2.7 дахь заалтыг үндэслэн 2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 373 тоот аймгийн Засаг даргын захирамжаар ойн ашиглалтын нөөц бүхий сумдын ойн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлж, ойн санг нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий “Сум дундын ойн анги”-ийг Хутаг-Өндөр сум болон Хялганат тосгонд тус тус байгуулсан байна.

Ойн тухай хуулийн 18.1.7-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ сумын ИТХ-ийн 12 дугаар сарын 18-ны өдрийн 2013 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн VIII/06 дугаар тогтоолоор Сэлэнгэ “Сумын ойн анги” ОНӨААТҮГ, Тэшиг сумын ИТХ-ын 2016 оны 03 дугаар сарын 14/03 дугаар тогтоолоор Тэшиг суман дахь Ойн анги тус тус байгуулагджээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны V дугаар хуралдааны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 2022 онд ойгоос 16541 м3 хэрэглээний, 87986 м3 түлээний мод бэлтгэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 14795.3 м3 хэрэглээний, 74862.0 м3 түлээний мод бэлтгэж, нийт 2834.5 м3 талбай тусгаарласан байна.

Орон нутгийн хэмжээнд 2022 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 551,861.4 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 530,394.5 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 21,466.8 мянган төгрөг буюу 96.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ойн тухай хуулийн 32.2¹ болон, улсын тэмдэгтийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3², 35.5³-д заасан гарал үүслийн гэрчилгээ олгох дээд, доод хязгаарыг батлаагүй байна.

¹ шаардлагатай тохиолдолд ойн анги болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтан ажиллуулах, шаардагдах төсвийг батлах;

² 6.3.Энэ хуулийн 29.1.12, 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

³ Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:-

БҮЛЭГ А. Ойн ангиуд холбогдох хууль, дүрэм журамд заасан эрх, үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, төсөв санхүү дутагдалтай байна.

А.1.1. Ойн ангиудын үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Ойн тухай хууль 2012 онд шинэчлэгдэн батлагдсан бөгөөд тус хуулийн 14.1⁴, 18.1.7⁵-д ойн анги байгуулах эрх зүйн орчин, 17 дугаар зүйлийн 17.1.6⁶, 18.3.13⁷-д санхүү төсөвтэй холбоотой асуудлыг, 17.2.7⁸, 18.2.9⁹-д бүтэц орон тоо, 18.3¹⁰-д Ойн ангийн эрх үүргийг тус тус тусгаж өгчээ.

Ойн тухай тухай хууль 2012 онд шинэчлэн батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2009 оны ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журмын заалтыг хуулийн өөрчлөлттэй холбож холбогдох заалтад өөрчлөлт оруулаагүй байгаад Байгаль орчин аялал жуулчлалын газар холбогдох дээд байгууллагад санал уламжлан шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

А.1.2. Ойн ангиудын бүтэц орон тоо, санхүүжилт харилцан адилгүй байна.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/49 дугаар тушаалын хавсралтаар баталсан Ойн ангийн үлгэрчилсэн дүрмийн 8.1¹¹-д ойн ангийн орлогын санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлж өгсөн байна.

Сумдын Ойн ангиудын санхүүжилтийн эх үүсвэр нь Ойн ангийн үлгэрчилсэн дүрэмд заасан доорх хүснэгт дэх орлогуудаас бүрджээ.

Хүснэгт 1 Ойн ангиудын үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэл /мян.төг/

Д/д	Сумдын нэрс	Аймгийн Засаг даргын багцад суусан орон нутгийн төсөв		Ажил, үйлчилгээнээс олсон орлого		Туслах үйл ажиллагааны орлого		Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэр	Нийт эх үүсвэр	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Булган сумын Ойн анги	48,556.2	48,556.2	23,800.0	40,615.0	0.00		47,889.2	72,356.2	137,060.0
2	Хутаг-Өндөр сумын Ойн анги	52,046.0	52,046.6	19,050.0	27,661.0	0		9,990.0	71,096.0	89,697.80

⁴ Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/, аймаг, нийслэлийн байгаль орчны газрын бүрэлдэхүүнд ойн асуудал хариуцсан нэгж буюу ойн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, аймаг, суманд сум дундын болон сумын ойн анги /цаашид "ойн анги" гэх/ ажиллана.

⁵ шаардлагатай тохиолдолд ойн анги болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтан ажиллуулах, шаардагдах төсвийг батлах;

⁶ ойн талбайн хэмжээний нормативыг харгалзан нутаг дэвсгэртээ байх ойн ангийн жагсаалт, тухайн жилийн төсвийг батлах.

⁷ ойн анги нь төсөв, түүнчлэн сургалт, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлсний болон өөрийн ажил, үйлчилгээний орлого зэрэг эх үүсвэрээс санхүүжих;

⁸ аймгийн байгаль орчны газрын харьяанд сум дундын ойн анги, нийслэлийн байгаль орчны газарт ойн асуудал эрхэлсэн нэгж байгуулж, бүтэц, орон тоог батлан, тэдгээрийн даргыг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх;

⁹ ойн ангийн дарга болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтныг томилох, чөлөөлөх;

¹⁰ Сум дундын болон сум, дүүргийн ойн анги нь дараах эрх, үүрэгтэй:

¹¹ 8.1.1 Аймгийн засаг даргын багцад суусан орон нутгийн төсөв

8.1.2 Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, тусламж, хандивлагч орнуудын зээл, буцалтгүй тусламж

8.1.3 Ажил, үйлчилгээнээс олсон орлого

8.1.4 Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэр

3	Тэшиг сумын Ойн анги			28,725.0	26,730.1	0	1,805.0		28,725.0	28,535.0
4	Хялганат тосгоны Ойн анги	36,342.3	32,667.0	33,375.0	84,674.8	0		9,990.0	69,717.3	127,331.8

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн тоо мэдээлэл

Ойн ангиуд нь үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөхдөө зөвхөн орон нутгаас санхүүжүүлэх орлого болон мод бэлтгэх гэрээний орлогыг төлөвлөсөн байгаа нь ойн ангийн үлгэрчилсэн дүрмийн 5 дугаар зүйлд Ойн ангийн эрх үүргийг тусгайлан заасан үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн маркетинг, менежментийн үр ашигтай, оновчтой бодлого хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Дээрхээс үзэхэд Ойн ангиудын ажил үйлчилгээнээс олох орлого давж биелж байгаа нь сайшаалтай ч мод бэлтгэх гэрээний дагуу тусгаарлалт хийлгэсэн талбайны орлого, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, НББ-ийн тухай хуулийн холбогдох зарим заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллахгүй байна. Тухайлбал:

Хутаг-Өндөр суман дахь сум дундын Ойн анги:

- Талбай тусгаарлалтын орлогыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, ямар сумаас хэдэн төгрөгийн талбай тусгаарлалтын авлага байгаа нь бүртгэл тооцоогүйгээс 9,429.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй нь НББ-ийн тухай хуулийн холбогдох заалт, Ойгоос мод бэлтгэх журмын 3.1-д "Ойн тухай хуулийн 33.1-д заасны дагуу мод бэлтгэх гэрээ байгуулсан, эсхүл 34.1-д заасны дагуу эрхийн бичиг олгогдсоноор ойгоос мод бэлтгэх эрх үүснэ", Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журмын 4.1-д "Иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг бүрэн төлсний дараа Ойн тухай хуулийн 34.1-д заасны дагуу эрхийн бичгийг олгоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн,
- Модны үр тарьц бэлтгэх, мод үржүүлгийн үйл ажиллагааг санхүүгийн тайланд тусгаж бүртгэл тайланд тайлагнаагүй,
- Иргэдийн хэрэгцээний модыг бэлтгэх талбай тусгаарлалтын мөнгийг иргэдээс мод бэлтгэх эрхийн бичгийн хамт иргэдээс авдаг боловч тус орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлсэн эсэхэд хяналт тавьж тооцоог хийж бүртгэл тайланд тусгаагүй,
- Ойн тухай хуулийн 34.1-д заасныг зөрчин мод бэлтгэх эрхийн бичиг олгож төсөвт төвлөрүүлэх 664.4 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн,

Тэшиг сумын Ойн анги:

- Ойгоос мод бэлтгэх журмын 3.1-д "Ойн тухай хуулийн 33.1-д заасны дагуу мод бэлтгэх гэрээ байгуулсан, эсхүл 34.1-д заасны дагуу эрхийн бичиг олгогдсоноор ойгоос мод бэлтгэх эрх үүснэ", Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журмын 4.1-д "Иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг бүрэн төлсний дараа Ойн тухай хуулийн 34.1-д заасны дагуу эрхийн бичгийг олгоно" гэсэн заалтыг зөрчин мод бэлтгэх гэрээний дагуу тусгаарлалт хийлгэсэн талбайны төлбөрийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй 4,692.7 мянган төгрөгийн авлага үүсгэж барагдуулаагүй,
- Иргэдийн хэрэгцээний модыг бэлтгэх талбай тусгаарлалтын мөнгийг иргэдээс мод бэлтгэх эрхийн бичгийн хамт иргэдээс авдаг боловч тус орлогыг төсөвт

бүрэн төвлөрүүлсэн эсэхэд хяналт тавьж тооцоог хийж бүртгэл тайланд тусгаагүй,

Хялганат тосгоны сум дундыг Ойн анги:

- Аймгийн Засаг даргын А/157 захирамжийг үндэслэн БОАЖГ-тай байгуулсан хамтын гэрээний 30 га талбайн арчилгааны гэрэлтүүлэх огтлолт хийхэд 10 хүн цалинжуулж ажиллахдаа НДШ, ХХОАТ төлсөн боловч 128.8 төгрөгийг дутуу тооцож илүү олгосон,
- Ойн ангийн шинээр худалдан авсан болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг орон нутгийн өмчийн асуудал хариуцсан байгууллагад тавьж шийдвэрлүүлээгүй байгаа зэрэг зөрчлүүдээс дүгнэхэд ойн ангиудын үйл ажиллагаанд тавих хяналт сул, үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Дээр дурдсан талбай тусгаарлалтын орлогыг дутуу тооцон, төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд нийт 10,093.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Ойн ангиуд нь дээр дурдсан орлогоос гадна үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлбэл үйл ажиллагаа явуулах санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэх боломжтой байна.Тухайлбал:

- Модны үр, тарьц, бэлтгэх ажлыг зохион байгуулах, мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа эрхлэх, тарьц суулгац худалдаалах,
- Аймаг, сумаас явуулж байгаа ойн нөхөн сэргээх, орон нутгийн, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулах,
- Ойн арчилгаа цэвэрлэгээгээр бэлтгэсэн модоор модон болон үртсэн хавтан үйлдвэрлэх шинэ, техник технологийг нэвтрүүлэх ажлын байрыг нэмэгдүүлэх боломжтойд шинэ маркетинг, менежментийн үр ашигтай, оновчтой бодлого хэрэгжүүлэх, аймаг орон нутаг, харьяалах дээд байгууллагаас дэмжиж ажиллах шаардлагатай байгаад холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

Ойн ангиудад нэн шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна.

Ойн газрын даргын 2009 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 50 дугаар тушаалаар баталсан дүрмээр Ойн алба 4, сум дундын ойн анги 5 орон тоотой байхаар заажээ.

Булган аймгийн хэмжээнд Ойн ангийн бүтэц орон тоог сумын ИТХ-аар нийт 16 орон тоо батлуулснаас гүйцэтгэлээр 12 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 8 нь ойн мэргэжлийн инженер техникч, экологич мэргэжлийн хүн ажиллаж байна.

Хүснэгт 2 Ойн ангиудын батлагдсан бүтэц, орон тоо, гүйцэтгэлийн судалгаа

Д/д	Орон тоо	Булган сум ойн анги		Хутаг-Өндөр ойн анги		Тэшиг сум ойн анги		Хялганат ойн анги	
		Баталсан	Гүйцэтгэл	Баталсан	Гүйцэтгэл	Баталсан	Гүйцэтгэл	Баталсан	Гүйцэтгэл
1	Дарга	1	1	1	1	1	1	1	1
2	Ойн инженер-ашиглалт	2	1	2	1	1	1	1	1
3	Ойн инженер-нөхөн сэргээлт нярав							1	
4	Нягтлан бодогч	1	0.5	1	1	1	0.5	1	1
5	Нярав					0			
6	Жолооч	1	1	0		0			
	Нийт дүн	5	3.5	4	3	3	2.5	4	3

Сум дундын ойн ангийн бүтэц орон тоог хүснэгт 1, 2-оос харахад нийт 16 орон тоогоор баталсан боловч гүйцэтгэлээр 12 орон тоогоор ажиллаж дутагдалтай 4 орон тоо байгаа нь ойн ангийн мэргэжлийн инженерийн орон тоо байна.

Аудитын явцад ойн ангиудын удирдлагуудтай ярилцлага хийхэд орон нутагт мэргэжлийн хүмүүс дутагдалтай учир мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангамж муу талаар дурдсан нь үндэслэлтэй байна.

Ойн ангийн үйл ажиллагааг явуулахад чухал шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний судалгаа хийж үзэхэд ойн инженерээр их, дээд сургууль төгсөж байгаа Булган аймгийн харьяалалтай иргэн 2022 онд 3 оюутан төгссөн байгаа нь хангалтгүй, хүрэлцээгүй байна.

Ойн ангийн үйл ажиллагаа нь талбай тусгаарлалт, ойжуулалт, мод үржүүлэг зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг боловч чухал боловсон хүчин болох инженер дутагдалтай байгаагаас ажлын ачаалал ихтэй, нэн шаардлагатай төсөв болох цалин хөлс бага, томилолт, шатахууны зардлыг холбогдох дээд байгууллагаас хангалттай баталж өгдөггүй, баталсан үйл ажиллагааны зардал хүрэлцдэггүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан бүтэц орон тоогоор ажиллах нөхцөл байдал бүрдэхгүй байна.

Цаашид Ойн инженер бэлдэж байгаа их сургуульд энэ чиглэлийн элсэлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажлыг зохион байгуулах, ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна.

Ойн ангиудын хариуцсан сумд, ойн нөөцийг болон бүтэц орон тоо санхүүжилттэй харьцуулахад харилцан адилгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 255 дугаар тогтоолоор сум дундын ойн ангийн хариуцах ойн талбайн норматив, байршлыг баталсан байна

Хүснэгт 3 Ойн ангиудын хариуцсан сумд, ойн нөөц болон бүтэц орон тоо санхүүжилтийн харьцуулсан судалгаа

Ойн ангийн нэрс	Хариуцсан сумдын тоо	ойн талбай /га/	Ойн бус талбай /га/	Нийт /га/	Эзлэх хувь	Батлагдсан орон тоо	Батлагдсан төсөв /мян.төг/	
							2021	2022
Булган сумын Ойн анги	6	332905	14125	347030	18.559	5	49,138.20	72,356.20
Хутаг-Өндөр сумын Ойн анги	2	377341	26913	404254	21.036	4	91,983.10	71,396.60
Тэшиг сумын Ойн анги	1	617027	46421	663448	34.398	3	0	17,327.61
Хялганат тосгоны Ойн анги	2	466536	32905	499441	26.008	4	104,722.80	80,792.71

Дээрх хүснэгтээс үзэхэд ойн сан бүхий нийт 11 сумын 1.793.809 га ойн талбайн 6 сумын 332.905 га буюу 18.6 хувийг Булган сумын Ойн анги дангаараа хариуцаж бусад сумын ойн анги 1-2 сумын 377.341-617.027 га буюу 21.0-34.4 хувийг хариуцаж байна.

Батлагдсан орон тоо болон төсвийг харьцуулан үзэхэд 6 сум хариуцаж буй Булган сумын ойн анги 5 орон тоотой 72.4 сая төгрөг, бусад ойн анги 3-4 орон тоотой 17.3-80.8 сая төгрөгөөр үйл ажиллагаа явуулахаар баталжээ.

Үүнээс үзэхэд орон тоо болон төсвийг харилцан адилгүй баталсан нь Ойн тухай хуулийн 17.3.3¹², 18.3-т заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна гэж дүгнэхээр байна.

Иймд ойн тухай хуулийн 18.3-т заасан эрх үүргийн хүрээнд ойн баялгийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг мэргэжлийн түвшинд орон нутагт хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа эсэхэд Байгаль орчин аялал жуулчлалын газар ойн тухай хуулийн 17.3.3¹³-д заасны дагуу дүн шинжилгээ хийж бодлогын түвшинд авч үзэн бүтэц орон тоо, үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр, үйл ажиллагааг дэмжих, хөтөлбөр гаргах талаарх саналаа аймаг, сумдын ИТХ, Засаг даргад танилцуулан шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагад тавин шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах зайлшгүй шаардлага үүссэн байна.

А.2.1. Ойн ангиуд нь хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт, Ойн ангийн үлгэрчилсэн дүрмийн 4 дүгээр зүйлд ойн ангийн чиг үүргийг тодорхой зааж өгсөн байна.

Хялганат тосгоны сум дундын Ойн анги нь 8-10 төрлийн мод үржүүлэгтэй 2022 онд мод үржүүлгээс 839 ширхэг суулгац борлуулж 1,069.0 мянган төгрөгийг төвлөрүүлж үйл ажиллагаандаа зарцуулсан сайн жишээ байна.

Хялганат тосгоны Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газар



Ойн ангиуд нь хуулиар заагдсан чиг үүргээс талбай тусгаарлах, гарал үүслийн гэрчилгээ олгох, модны үр, тарьц бэлтгэх ажлыг зохион байгуулах, мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа эрхлэх Ойн баялгийн нөөцийг ашигласны төлбөр, хураамжийг ногдуулж гүйцэтгэлийг хангах, иргэдэд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой хээрийн түймрээс хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулж зөрчлийг арилгах, ойн дагалт баялгийн цаг хугацааны судалгааг хийх, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хэмжээг тогтоох зэрэг чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- ✓ Хутаг-Өндөр сумын Ойн анги нь гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журмын 5.7-д "Ойн анги, сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголт, үлдэгдлийн тайланг улирал тутамд гаргаж, улирал бүрийн эхний сарын 10-ны дотор Байгаль орчны газарт, Байгаль орчны газар нь тухайн сарын 15-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ" гэсэн

¹² өөрийн харьяа ойн ангийг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих

¹³ өөрийн харьяа ойн ангийг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

заалтыг тус тус зөрчин гарал үүслийн гэрчилгээ, мод бэлтгэх эрхийн бичгийн тооцоог бодож тулгалт хийгээгүйгээс нийт 757 ш гарал үүсэл, 14 мод бэлтгэх эрхийн бичиг дутагдсан зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн,

- ✓ Хутаг-Өндөр сумын Ойн анги нь гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журмын 4.1-д "Иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг бүрэн төлсний дараа Ойн тухай хуулийн 34.1-д заасны дагуу эрхийн бичгийг олгоно" гэсэн заалтыг зөрчин 2,605.8 мянган төгрөг,
- ✓ Тэшиг сумын Ойн анги нь гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журмын 4.1-д "Иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг бүрэн төлсний дараа Ойн тухай хуулийн 34.1-д заасны дагуу эрхийн бичгийг олгоно" гэсэн заалтыг зөрчин 633.0 мянган төгрөг,
- ✓ Хутаг-Өндөр сумын Ойн анги нь Ойн тухай хуулийн 34.1-д заасныг зөрчин мод бэлтгэх эрхийн бичиг олгож төсөвт төвлөрүүлэх орлогыг 664.6 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, авлага, өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- ✓ Булган сумын ойн анги нь БОАЖС-ын 2022 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн А/282 тоот тушаалаар 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/166 тоот тушаалыг хүчингүй болсон тул Ойн дагалдах нөөц ашиглах 12101-12400 сери дугаартай 300 ширхэг эрхийн бичгийг бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Мөн Ойн ангиуд нь ойн ангийн үлгэрчилсэн дүрмийн 4 дүгээр зүйлд заагдсан доорх ажлыг огт хэрэгжүүлэн ажиллахгүй байна.Үүнд:

- Байгаль орчны тухай болон Ойн хууль, ой түүний дагалт баялаг, биологийн төрөл зүйлийг тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ гүйцэтгэхэд нь сумын Засаг даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч,
- Ойн дагалт баялгийн цаг хугацааны судалгааг хийх, ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар бэлтгэх хэмжээг тогтоох,
- Ойн хөнөөлт шавж, өвчний голомтын тойм судалгаа хийж дүгнэлт гаргах, ойн төлөв байдалд үнэлгээ өгөх, ойн тооллого, бүртгэл, зохион байгуулалт, хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлын явцад хяналт шинжилгээ хийх.

Сумдын Ойн анги нь үйл ажиллагааны үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа талаар тодруулахад шаардлагатай хүний нөөц дутагдалтай, санхүүжилт хангалтгүй зэрэгтэй холбон тайлбарлаж байна.

Цаашид чиг үүрэгт заасан үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ойн ангиуд орлогоо нэмэгдүүлэх санхүүжилтийн эх үүсвэр байгаад идэвх санаачилгатай ажиллах, холбогдох хууль дүрэм журамд заасан эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх, нөөц боломжоо бүрэн дайчлан ажиллах, эрхийн бичгийн зарцуулалтыг холбогдох дээд шатны байгууллагад нэгтгүүлэх, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулан тухай бүр хуульд заасан хугацаанд тайлагнах шаардлагатай гэж дүгнэлээ.

А.2.2. Ойн ангиуд чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хүрэлцээгүй байна.

Ойн ангиудын батлагдсан төсөв, зарцуулалтад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 4 Ойн ангиудын 2022 оны батлагдсан төсөв

/төгрөг/

№	Зардлын ангилал	Булган сум	Хутаг-Өндөр сум	Хялганат тосгон	Тэшиг сум
1	Дээд шатны байгууллагат хүргүүлсэн төсвийн санал	105,804.3	86,367.1	92,721.7	
2	Дээд шатны байгууллагаас баталсан төсөв	72,356.2	71,096.6	80,712.3	154,471.6
3	Буурсан/өссөн дүн	33,448.1	15,270.5	12,009.4	

Хүснэгт 5 Ойн ангиудын цалингийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөг/

№	Сумын ойн ангийн нэр	Цалин хөлс төлөвлөгөө	Цалин хөлс гүйцэтгэл	Цалин хөлс зөрүү
1	Булган сум	43,599,800	35,761,489	7,838,311
2	Хутаг-өндөр сум	45,999,200	39,965,182	6,034,017.79
3	Тэшиг сум	18,519,978	18,214,636.52	305,341
4	Хялганат тосгон	47,175,300	41,841,300	1,669,250
	Нийт дүн	155,294,278	135,782,308	15,846,920

Хүснэгт 6 Ойн ангиудын тээвэр шатахууны төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөг/

№	Сумын ойн ангийн нэр	Тээвэр шатахуун төлөвлөгөө	Тээвэр шатахуун гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт
1	Булган сум	2,914,100	2,919,100	-5,000
2	Хутаг-өндөр сум	3,000,000	4,149,500	-1,149,500
3	Тэшиг сум	1,000,000	998,660	1,340
4	Хялганат тосгон	3,400,000	3,400,000	0
	Нийт дүн	10,314,100	11,467,260	-1,155,840

Хүснэгт 7 Ойн ангиудын томилолтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөг/

№	Сумын ойн ангийн нэр	Томилолт төлөвлөгөө	Томилолт гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт
1	Булган сум	160,000	160,000	0
2	Хутаг-өндөр сум	300,000	246,000	54,000
3	Тэшиг сум	700,000	244,000	456,000
4	Хялганат тосгон	660,000	660,000	0
	Нийт дүн	1,820,000	1,310,000	510,000

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан баталгаажуулах тайлангийн үзүүлэлт

Дээрхээс үзэхэд Ойн ангиуд батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаагүйтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 2022 онд нийт 15,846,920 төгрөг хэмнэгдсэн байна.

Мөн зарим ойн ангийн шатахуун, томилолтын зардлыг хэмнэсэн, хэтэрсэн байгаа боловч Ойн анги нь мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлтэй байгуулсан талбай тусгаарлалтын гэрээний дагуу жилдээ дунджаар Булган сумын СДОА 97,

Хялганат тосгоны СДОА 161, Хутаг-Өндөр сумын СДОА 76, Тэшиг сумын ойн анги 47 удаа талбай тусгаарлалтын ажлаар ойн сав газар ажиллаж, нэг удаагийн талбай тусгаарлалт явахдаа 300-500 км явах, хийж шаардлагатай үед 2-7 хоног хөдөө ууланд ажиллаж байгаа боловч томилолтын зардал, тээвэр шатахууны зардал хангамж хүрэлцээгүй байдаг байна.

Дээрх хүснэгт 6,7-оос харахад Хутаг-Өндөр сумын СДОА, Булган сумын СДОА шатахууны зардлыг төлөвлөгөөнөөс 1,154.0 мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь Тэшиг сум, Хялганат тосгоны СДОА-аас газар нутгийн хэмжээ, ойн сангийн хэмжээтэй харьцуулахад том, талбай тусгаарлалтын ажлаар явахдаа 5-10 газар тусгаарлалтыг хийхэд 30-1000 орчим километр замыг туулж 2-7 хүртэл хоногоор ажиллах тохиолдол байдагтай холбоотой байна.

Үйл ажиллагаа явуулах шатахууны зардал, томилолтын зардлыг хангалтгүй батлуулснаар хүний нөөцийн дутагдал, ажлын ачаалал нэмэгдэх гол шалтгаан болж байгаад дүн шинжилгээ хийж холбогдох дээд байгууллагууд анхаарч үзэн зохих шийдвэрийг гаргаж ажиллах, Засгийн газрын 255 дугаар тогтоолын ойн ангийн бүтэц орон тоо, үйл ажиллагаатай холбоотой ажлыг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ Б. Ойн ангиудын үйл ажиллагаанд холбогдох эрх бүхий байгууллагууд хяналт тавиагүй, зарим хуулиар хүлээсэн эрх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Б.1.1. Харьяалах дээд байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Ойн тухай хуулийн 8 дугар зүйлийн 17 дугаар зүйлийн 3.3¹⁴-д, 17.1.1¹⁵, 18.2.2¹⁶, 18.2.4¹⁷, 18.2.6¹⁸, Байгаль орчин аялал жуулчлалын газар, сумын ИТХ, Засаг дарга нь ойн ангиудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр заасан байна.

Хүснэгт 8 Харьяалах дээд байгууллагаас ойн ангиудад хийсэн хяналт шалгалт

Д /д	Ойн ангийн нэрс	Ойн газар	Аймаг ИТХ	Сум ИТХ	Аймаг ЗДТГ	Сум ЗДТГ	БОАЖГ
1	Булган сумын Ойн анги	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй
2	Хутаг-Өндөр сумын ойн анги	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй
3	Тэшиг сумын ойн анги	Хийгээгүй	Хийгээгүй	Хийсэн	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй
4	Хялганат тосгоны ойн анги	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй	Хийгээгүй

¹⁴ “өөрийн харьяа ойн ангийг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих”

¹⁵ ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавих;

¹⁶ ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

¹⁷ ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах талаарх ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, тэдний тарьж ургуулсан таримал ойг хүлээн авах;

¹⁸ энэ хуулийн 18.1.4-т заасан шийдвэрийг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг болзол, хугацаатайгаар эзэмшүүлэх гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

Дээрх хүснэгтээс дүгнэхэд 2022 оны байдлаар ойн ангиудын үйл ажиллагаанд Тэшиг сумын ИТХ-аас бусад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгээгүй байна.

Цаашид ойн ангиудын үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулж сайжруулах, тухай бүр мэргэжлийн удирдлагаар хангах шаардлагатай байна.

Б.1.2. Аймаг, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аймаг, сумдын ИТХ-ын үүргийг ойн тухай хуулийн 17.1.4¹⁹, 32.2²⁰, 18.1.5²¹, 18.1.6²², дахь заалтад Аймаг, сумдын Засаг даргын үүргийг ойн тухай хуулийн 17.2.2²³, 17.2.4²⁴, 17.2.10²⁵, 18.2.6²⁶, 18.2.7²⁷, 18.2.8²⁸ дахь заалтад тус тус хуульчилжээ.

Ойн тухай хуулийн 4.4.2-д сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн сангийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаа, нөхцөл, болзолтойгоор гэрээний дагуу ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад ойн санг эзэмшүүлэхээр заасан байна.

ИТХ, засаг дарга нар Ойн тухайн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4²⁹, 18.1.5³⁰, 18.2.6³¹ заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй, мөн ойн тухай хуулийн 18.1.7³², 18.2.3³³ эрх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс ойн ангийн үйл ажиллагаа явуулах төсөв хангалтгүй, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ дутах, төсөвт төвлөрүүлэх орлогыг ойн ангиуд бүрэн төвлөрүүлэхгүй байх зэрэг алдаа зөрчил давтагдсаар байна.

Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэх, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавиагүй, хуульд заагдсан чиг үүргээ биелүүлсэн эсэхийг дүгнээгүй атлаа орон нутгийн ИТХ, Засаг дарга нар мод бэлтгэх эрх олгож байна гэж дүгнэгдэхээр байна.

Цаашид ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа аж ахуй нэгж байгууллага, нөхөрлөлийн үйл ажиллагаанд нь тавих хяналтыг сайжруулан, ойн сангийн тодорхой хэсгийн эзэмшүүлсэн гэрээний биелэлтийг дүгнэж ажлыг хэвшил болгох,

¹⁹ төрийн захиргааны төв байгууллагын баталсан дээд хязгаарт багтаан тухайн жилд ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээний хэмжээг сумдаар хуваарилан батлах;

²⁰ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээг энэ хуулийн 32.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүрэг бүрээр тогтооно

²¹ Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлсэн гэрээний биелэлтийг жил бүр хэлэлцэн дүгнэж байх;

²² Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх бодлого, чиглэлийг батлах, хяналт тавих;

²³ Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, биелэлтийг хангах"

²⁴ тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

²⁵ Ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

²⁶ энэ хуулийн 18.1.4-т заасан шийдвэрийг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг болзол, хугацаатайгаар эзэмшүүлэх гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

²⁷ ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хязгаарт багтаан мод бэлтгэх шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих;

²⁸ Ойн нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх;

²⁹ баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэх, хяналт тавих;

³⁰ .ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлсэн гэрээний биелэлтийг жил бүр хэлэлцэн дүгнэж байх;

³¹ энэ хуулийн 18.1.4-т заасан шийдвэрийг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг болзол, хугацаатайгаар эзэмшүүлэх гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

³³ энэ хуулийн 34.1, 38.1-д заасны дагуу эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг олгоход хяналт тавих, уг эрхийн бичиг, гэрчилгээг үндэслэлгүй олгосон нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох;

хуулиар олгогдсон хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, сайжруулах шаардлагатай байна.

Мөн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ойн тухай хуулийн 32.2³⁴ болон, улсын тэмдэгтийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3³⁵, 35.5³⁶-д заасан гарал үүслийн гэрчилгээ олгох дээд, доод хязгаарыг батлаагүй байна.

Энэ нь ойн ангиуд иргэдээс гарал үүслийн гэрчилгээний тэмдэгтийн хураамжийг харилцан адилгүй хэмжээгээр хураан авах нөхцөлийг бүрдүүлж байгаад анхаарч холбогдох шийдвэрийг гаргах шаардлагатай байна.

БҮЛЭГ В. Ойн нөхөрлөл, аж ахуй нэгж, байгууллага, ойн мэргэжлийн байгууллагууд хуульд заасан үүргээ үр дүнтэй бүрэн хэрэгжүүлээгүй байна.

В.1.1. Ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх менежментийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 227 тогтоолоор “Ойн санг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх журам”-ын журмын дагуу аймгийн хэмжээнд 215 нөхөрлөл байгуулагдсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 187 ойн нөхөрлөл бүртгэлтэйгээс 2022 оны байдлаар 33 нөхөрлөл үйл ажиллагаа явуулсан ба 154 нөхөрлөл үйл ажиллагаа явуулаагүй зогсонги байдалтай байгаа нь аймгийн хэмжээнд ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитын явцад ойн сан бүхий сумын Засаг дарга ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг ИТХ-аар хэлэлцүүлээгүй, ойн нөхөрлөлүүдтэй байгуулсан гэрээний биелэлтийг сумдын Засаг дарга дүгнээгүй, ойн нөхөрлөлүүд нь хууль тогтоомжид нийцсэн дүрэм, ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлээгүйгээр үйл ажиллагаа явуулж Ойн тухай хуулийн 4.7³⁷, 9.3³⁸, 17.3.9,³⁹ 21.1.⁴⁰, 21.2.⁴¹, 21.3.⁴², 21.11⁴³ дэх заалт, байгаль орчныг хамгаалах тухай хуулийн тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Ойн нөхөрлөлүүдийн менежментийн төлөвлөгөөг тайлагнаж дүгнүүлээгүй,
- Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 227 тогтоолоор “Ойн санг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх журам” баталсан боловч дээрх журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Иймд ИТХ-аар ойн нөхөрлөлүүдийн менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлж байх, сумдын Засаг дарга хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд удаа дараа дээрх

³⁴ шаардлагатай тохиолдолд ойн анги болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтан ажиллуулах, шаардагдах төсвийг батлах;
³⁵ 6.3.Энэ хуулийн 29.1.12, 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

³⁶ Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:-

³⁷ Энэ хуулийн 4.4.2-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нь ойн менежментийн төлөвлөгөөний дагуу эзэмшлийнхээ ойг хамгаалах, энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу мод, дагалт баялгийг ашиглах, ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах, нөхөн сэргээх арга хэмжээг авна.

³⁸ Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан ойн менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна.

³⁹ ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

⁴⁰ Ойн нөхөрлөл нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байна.

⁴¹ Ойн нөхөрлөл нь хууль тогтоомжид нийцсэн дүрэмтэй байна.

⁴² Ойн нөхөрлөл нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр тавина.

⁴³ Дараах тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшиж хамгаалах чиглэлээр явуулах ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцална:

зөрчлийг гаргасан ойн нөхөрлөлийн ойн санг гэрээгээр эзэмших гэрээний ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмж хүргүүллээ.

В.1.2. Ойн мэргэжлийн байгууллага, аж ахуй нэгж байгууллага ойжуулалтын ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт 35 аж ахуй нэгж, байгууллага нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшиж үйл ажиллагаа явуулж байна.

Аж ахуй нэгж, байгууллагын үүргийг Ойн тухай хуулийн 17.3.9⁴⁴, 22.1.3⁴⁵, 22.1.11⁴⁶, 22.2⁴⁷ дахь заалтад тус тус тодорхойлжээ.

Ойн санг гэрээгээр эзэмшиж ирсэн мэргэжлийн байгууллагын гэрчилгээ авсан зарим ААНБ-ын үйл ажиллагаатай танилцахад мэргэжлийн байгууллагын гэрчилгээний хугацаа дууссан, гэрээний үүргээ биелүүлээгүй, ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа явуулах чиглэл, заалтыг зөрчиж мод бэлтгэх ажиллагаа явуулж байгаа зөрчил илэрч байна. Тухайлбал:

- Тэшиг сумын “Монгол гео каратаж” ХХК-ий 2018 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/380 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар ойн мэргэжлийн байгууллагын эрхийг хүчингүй болгосон байхад 457 м3 мод бэлтгэх эрхийн бичиг олгосон. Энэ нь “Тэшиг трийс” ХХК-тай гэрээ байгуулан мод бэлтгүүлсэн гэх боловч тухайн 2 байгууллагын байгуулсан гэрээ байхгүй, экологийн хариуцлагын гэрээ байгуулаагүй байна.

Мөн зарим аж ахуй нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг үзэхэд зарим аж ахуй нэгжийн менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт байхгүй, БОАЖГ-т тухай мэдээллийн талаарх судалгаа мэдээ, мэдээллийн сан бүрэн бус, сумдын ИТХ-аар төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцүүлээгүй зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Тэшиг сумын аж ахуй нэгж байгууллагууд нийт дүнгээрээ 8.37 га талбайд,
- Хутаг-Өндөр сумын аж ахуй нэгж байгууллагууд нийт дүнгээрээ 11.2 га талбайд
- Булган сумын аж ахуй нэгж байгууллагууд нийт дүнгээрээ 13.2 га талбайд тус ойжуулалтыг гүйцэтгээгүй байна. /Хавсралт-1/

Энэ нь шат шатны эрх бүхий байгууллагуудын хяналт сул байгаатай холбоотойгоор аж ахуйн нэгж байгууллагууд дээрх хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Цаашид хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуй нэгж, байгууллагад хариуцлага тооцох, үүргийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгаад анхаарч зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүллээ.

⁴⁴ Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

⁴⁵ Ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшсэн аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр явуулах үйл ажиллагааны ойн

⁴⁶ жил бүр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаар тайлан тавьж, ажлаа дүгнүүлэх;

⁴⁷ Тухайн сум, дүүргийн Засаг дарга нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дараах үндэслэлээр зогсоож, гэрээг цуцална;

ДҮГНЭЛТ: Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Ойн ангиудын үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.
- Ойн тухай тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2009 оны ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журмын заалтыг хуулийн өөрчлөлттэй нийцүүлэн холбогдох заалтад өөрчлөлт оруулаагүй байна.
- Ойн ангиудын үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас мод бэлтгэх гэрээний дагуу тусгаарлалт хийлгэсэн орлогыг тооцоогүй, авлагыг тооцоо, нийлж баталгаажуулаагүй, үнэт цаасны тооцоо, тайланг хийж хэвшээгүй, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн төсөвт төвлөрөх орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Ойн ангиуд нь дээр дурдсан орлогоос гадна үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлбэл үйл ажиллагаа явуулах санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэх боломжтой байна
- Ойн ангиудад шаардлагатай боловсон хүчин дутмаг, цалин бага, томилолт, шатахууны зардлыг хангалттай баталдаггүй, батлагдсан төсөв хүрэлцээгүй байгаа зэрэг шалтгаанаар ойн баялгийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг мэргэжлийн түвшинд орон нутагт хэрэгжүүлэх чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаад дүн шинжилгээ хийж бодлогын түвшинд авч үзэн бүтэц орон тоо, үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр, үйл ажиллагааг дэмжих, хөтөлбөр гаргах талаарх саналаа аймаг, сумдын ИТХ, Засаг даргад танилцуулан шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагад тавин шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.
- Ойн ангиуд нь ойн ангийн үлгэрчилсэн дүрмийн 4 дүгээр зүйлд заагдсан зарим чиг үүргийг огт хэрэгжүүлж ажиллахгүй байна
- 2022 оны байдлаар ойн ангиудын үйл ажиллагаанд Тэшиг сумын ИТХ-аас бусад байгууллага, албан тушаалтан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгээгүй байна.
- Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавиагүй, хуульд заагдсан чиг үүргээ биелүүлсэн эсэхийг дүгнээгүй байхад орон нутгийн ИТХ, Засаг дарга нар мод бэлтгэх эрх олгож байна.
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ойн тухай хуулийн 32.2⁴⁸ болон, улсын тэмдэгтийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3⁴⁹, 35.5⁵⁰-д заасан гарал үүслийн гэрчилгээ олгох дээд доод хязгаарыг батлаагүй байна
- Сум дундын ойн ангиудын үйл ажиллагааны зардлыг харилцан адилгүй баталж байна.
- Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагын ойжуулалтын ажил хангалтгүй хийгдэж байна.

⁴⁸ шаардлагатай тохиолдолд ойн анги болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтан ажиллуулах, шаардагдах төсвийг батлах;

⁴⁹ 6.3.Энэ хуулийн 29.1.12, 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

⁵⁰ Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:-

ЗӨВЛӨМЖ: Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ийн дарга Д.Эрдэнэбат танаа:

- Сумдын ИТХ-д ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.3.8, 18.12 дахь заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллах чиглэл өгөх.
- Ойн тухай хуулийн 32.2⁵¹ болон, улсын тэмдэгтийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3⁵², 35.5⁵³-д заасан гарал үүслийн гэрчилгээ олгох дээд, доод хязгаарыг батлах.

Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ танаа:

- Ойн мэргэжлийн байгууллага, ойг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн мод бэлтгэх гэрээ, ажлын тайланг хууль, журамд заасан хугацаанд хэлэлцэн, үр дүнг тооцож байх чиглэлийг ойн сан бүхий сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлж биелэлтийг хангуулж ажиллах.

Байгаль орчин аялал жуулчлалын дарга А.Гантөмөр танаа

- Сум дундын болон сумын ойн ангийн ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласан хэмжээ, төлбөрийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих, мэдээллийн санг бий болгож, архивлах.
- Ойн ангиудын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг шийдвэрлэх асуудалд анхаарах, улсын хэмжээнд явагдаж байгаа хөтөлбөрүүдэд хамруулах, шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага, иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад санал хүргүүлэх ажлыг дэмжин зохион байгуулах.

Ойн ангиудын дарга нарт:

- Сумдын байгаль хамгаалагчдын олгосон эрхийн бичгийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг татварын байцаагчаар баталгаажуулан тайлан мэдээг гаргаж байх.
- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлсний үндсэн дээр эрхийн бичгийг олгож байх, үүссэн авлагыг тайлант жилд багтаан барагдуулах.
- Ойн ангийн үлгэрчилсэн дүрмийн 4 дүгээр зүйлд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
- Ойн ангийн үлгэрчилсэн дүрмийн 4.2.4-д заасан модны үр, тарьц бэлтгэх ажлыг зохион байгуулах, мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа боловч байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд бүртгэх.
- Ойн ангийн үйл ажиллагааны орлогыг бодитой тоо, мэдээлэл судалгаанд үндэслэн тооцох, тухай бүр орон нутгийн холбогдох дансанд бүрэн төвлөрүүлж байх.

⁵¹ шаардлагатай тохиолдолд ойн анги болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтан ажиллуулах, шаардагдах төсвийг батлах;

⁵² 6.3.Энэ хуулийн 29.1.12, 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

⁵³ Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:-

Саналд өгсөн тайлбар:

Байгаль орчин аялал жуулчлалын газраас 3 санал, Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангиас 1 тайлбар, Тэшиг сумын ойн ангиас 1 тайлбар аудитын баг нягтлан үзэж саналтай холбоотой дараах тайлбарыг өгч байна.

Булган аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт

Саналд өгөх тайлбар	
БуААГ-ын тайлбар 1	Сум дундын ойн ангиудын төсөв, санхүүжилттэй холбоотой зөвлөмжийг хүргүүлсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
БуААГ-ын тайлбар 2	Сумын ИТХ, ойн нөхөрлөл, аж ахуй нэгжийн ойн менежментийн төлөвлөгөөг дүгнэж, холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүл байгаа тул саналыг хүлээж авах боломжгүй
БуААГ-ын тайлбар 3	Сумдын байгаль хамгаалах санд хэрэгцээний модны ойжуулалтын зардлыг төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй мөн, төвлөрүүлсэн гэх хангалттай зохистой анхан шатны баримт ирүүлээгүй тул тайлбарыг хүлээн авах боломжгүй байна

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангид

Саналд өгөх тайлбар	
БуААГ-ын тайлбар 1	Ойн мэргэжлийн байгууллага нь ойжуулалтын нөхөн сэргээлтийн зардлыг байгаль хамгаалах санд төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй, мөн төвлөрүүлсэн гэх хангалттай зохистой нотлох баримт ирүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Тэшиг сумын ойн ангид

Саналд өгөх тайлбар	
БуААГ-ын тайлбар 1	Ойн мэргэжлийн байгууллага нь ойжуулалтын нөхөн сэргээлтийн зардлыг байгаль хамгаалах санд төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй, мөн төвлөрүүлсэн гэх хангалттай зохистой нотлох баримт ирүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.